

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.100

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Будгийн ажил. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS XXXX:XXXX
Occupational Safety and Health. Painting Works. General Safety Requirements	MNS 12.3.006-84-ийн оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь оны дүгээр сарын-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь лак, будгийн материал (лак, нунтаг будаг, паалан-грунт, шпатлёнк)-ыг ашиглан будгийн ажил хийж гүйцэтгэхэд хамаарах бөгөөд эдгээр ажлыг бэлтгэх болон гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагыг тогтооно.

Уг стандарт нь барилга, байгууламжийн барилга угсралт, засварын үеийн будгийн ажил болон радио идэвхтэй лак, будгийн материал ашигласан ажилд хамаарахгүй.

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

MNS 4990, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисын хэмжилд тавигдах ерөнхий шаардлага, зөвшөөрөгдөх дээд хэмжээ

3 Ерөнхий зүйл

3.1 Зорилго

Ажлын байранд будгийн ажил гүйцэтгэх үед хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндсэн шаардлагыг тодорхойлон, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажлын орчны аюулгүй байдлыг хангахад оршино.

4 Зарчим

4.2 Будгийн ажлыг гүйцэтгэх явцад дараах үе шат бүрд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллах ёстой. Үүнд:

- 4.2.1** Ажлын бэлтгэл хангах - Ажлыг эхлүүлэхийн өмнө ажил гүйцэтгэх бүрэлдэхүүнийг тодорхойлж, ажилтнуудад заавар, үүрэг даалгаврыг өгч, шаардлагатай хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, бэлэн байдлыг шалгах.
- 4.2.2** Будагдах гадаргууг бэлтгэх-Будаг түрхэх эд зүйлсийн гадаргууг тос, зэв, хуучин будаг болон бусад бохирдлоос механик болон химийн аргаар цэвэрлэж, зэврэлтээс хамгаалах бодис түрхэх.
- 4.2.3** Будгийн ажлыг гүйцэтгэх-Будаг, лакийг аюулгүй нөхцөлд түрхэх ба энэ үед тэсрэмтгий, хорт ууршил үүсэхээс сэргийлж хангалттай агааржуулалттай орчин бүрдүүлнэ. Ажилтнууд тохирсон амьсгал хамгаалах хэрэгсэл, нүдний шил, бээлий зэрэг хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглэх ёстой.
- 4.2.4** Будсан гадаргууг хатаах-Будаг хатаах үйл явц нь аюулгүй орчинд явагдах ба хатаах өрөө, агааржуулалтын системийн хэвийн үйл ажиллагааг хянаж, галын аюулгүй байдлыг бүрэн хангах.
- 4.2.5** Будсан гадаргууг боловсруулж дуусгах-Будаг хатсаны дараа гадаргууг зүлгэх, өнгөлөх зэрэг боловсруулалтын ажил гүйцэтгэх үед үүсэх тоос, жижиг ширхэгт бодисын өртөлтөөс сэргийлэх сорох төхөөрөмж, хамгаалах хэрэгсэл ашиглах.
- 4.2.6** Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг цэвэрлэх-Ажлын дараа ашигласан багаж хэрэгсэл, сав, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу угааж цэвэрлэж үүссэн хог, хаягдлыг ангилан ялгаж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байдлаар устгах
- 4.3** Будгийн ажлын үед технологийн тоног төхөөрөмж (камер, аппарат гэх мэт), үйлдвэрлэлийн байр, талбай болон тэдгээрийн орчинд ил гал гаргах, дэлбэрэлт үүсэх нөхцөлийг бүрэн арилгаж, үйлдвэрлэлийн явцад бий болох аюултай, хортой хүчин зүйлсээс ажилтныг хамгаалах шаардлагатай бүх арга хэмжээг авсан байх ёстой.

5 Технологийн үйл ажиллагаанд тавих шаардлага

- 5.1** Будгийн ажил нь бохир агаар гаргах, цэвэр агаар оруулах агааржуулалтын тусгай системтэй, галын техникийн хэрэгслээр тоноглогдсон будгийн цех, тасаг, хэсэг, талбайд гүйцэтгэгдэх бөгөөд будгийн төхөөрөмж, камеруудад хортой бодис ялгарч хуримтлагдахаас сэргийлсэн агаар солилцуулах төхөөрөмжийг байрлуулна.
- 5.1.1** Агааржуулалтын систем нь агаар дамжуулах хоолойн бохирдлыг бууруулах, цэвэрлэх зориулалт бүхий төхөөрөмжөөр тоноглогдсон байх ёстой.
- 5.1.2** Дэлбэрэх, гал гарах шинж чанартай, хордуулах бодис агуулсан лак, будгаар вагон, онгоц болон бусад том оврын эд зүйлсийг будах үед ажлын байрыг хэсгийн агааржуулалтын төхөөрөмжөөр тоноглогдсон байна.
- 5.1.3** Онцгой тохиолдолд эрх бүхий байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр овор ихтэй эдийг угсралтын ажлын байранд тусгай агааржуулалтын системгүйгээр будахыг зөвшөөрнө. Энэ тохиолдолд ажлыг дараах нөхцөлд гүйцэтгэнэ. Үүнд:
 - а. Бусад ажил явагдаагүй үед

- b. Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх зориулалттай агаар солилцуулах систем нь хэвийн, тасралтгүй ажиллаж байх үед
 - c. Ажилтны хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглэсэн үед
 - d. Галын болон дэлбэрэлтийн аюулаас хамгаалах нэмэлт арга хэмжээ авсан үед
- 5.2** Будгийн цех, хэсгийг шинээр төлөвлөх, өргөтгөх үед үйлдвэрлэлийн явцад үүсэх аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах, арилгах нөхцөлийг хангахуйц үйлдвэрлэлийн хэрэгслийг тооцон төлөвлөнө.
- 5.3** Будгийн ажлыг бэлтгэх болон гүйцэтгэх явцад асгарсан, цацарсан будаг болон химийн бодисыг цэвэрлэж, аюулгүй байдлаар зайлуулах арга хэмжээг шуурхай авна.
- 5.4** Будгийн материал болон хэрэглэгдэх хий, дулаан, цахилгаан энергийг технологийн төхөөрөмжид хүргэх явцад ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангасан байх ёстой.
- 5.5** 1м³ багтаамжтай технологийн аппаратад шатах шингэнийг юүлж авах зориулалтын юүлүүр байх ёстой.
- 5.6** Будаг болон будгийн ажлын бүрдлийг агааржуулалтын системээр тоноглогдсон, галын аюулаас хамгаалах хэрэгсэл бүхий тусгай байранд төвлөрүүлэн бэлтгэнэ.
- 5.7** Ажлын хэрэгсэл, сав суулгыг агааржуулалтын системтэй зориулалтын байранд цэвэрлэж, угаана.
- 6 Будгийн цех, хэсгийн байранд тавих шаардлага**
- 6.1** Будгийн цех, хэсэг болон чөлөөт талбай бүхий ажлын байрыг зохион байгуулах, тоноглохдоо агаарын температур, харьцангуй чийгшил, ажлын бүсийн агаарын урсгалын хурд зэрэг хүчин зүйлийг мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсгэх эрсдэлгүй байхаар тохируулах ёстой.
- 6.2** Будах хэсэг, талбайг тусгаарлагдсан орчинд байрлуулна. Хэрэв уг хэсэг нь гал түймэр гарах, дэлбэрэх аюул бүхий үйлдвэрлэлийн технологийн дамжлагад хамаарч байвал үйлдвэрийн дотор болон гадна талбайд байршуулахыг зөвшөөрнө.
- 6.3** Будах хэсэг, талбай нь хэсгийн агааржуулалтын системээр тоноглогдсон бөгөөд аюулгүй ажиллагааны таних тэмдэг, анхааруулгаар тэмдэглэгдсэн байх ёстой.
- 6.4** Гал түймэр, дэлбэрэлт үүсгэж болзошгүй шинж чанартай лак, будгийн шингэн материалыг ашиглах тохиолдолд тоноглох бүсээс 5 метрийн радиуст орших орчныг аюултай бүсэд хамааруулна.
- 6.5** Овор ихтэй эдийг шингэн будгаар задгай орчинд будах үед тухайн ажлын байр нь тусгаарлагдсан, хаалттай байхаас гадна цацарсан будаг, бохирдсон агаарыг сорж гаргах төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Мөн ажлын талбайн зах болон будаж буй эд зүйлийн дээд цэгээс 5 метр өндөр хүртэлх радиустай орчныг гал түймэр, дэлбэрэлт үүсэх эрсдэлтэй, аюултай бүсэд хамааруулна.
- 6.6** Үйлдвэрлэлийн талбайд байгаа тоног төхөөрөмжийн ажиллагааны үед ялгарч байгаа тоос, шорооны (жишээлбэл, нунтаг болон будгийн хэсэгт хуурай

зүлгүүрийн боловсруулалтаас үүсэх) шаталт үүсэж болох хольцын дээд хэмжээ нь 65 г/м^2 байвал уг байрыг бүхэлд нь галын дэлбэрэх аюултай үйлдвэрлэл явагдаж байна гэж үзнэ. Тоос, шороо үүсгэдэг хэсгийг галд тэсвэртэй хаалтуудаар тусгаарлах хэрэгтэй. Энэ тусгаарласан хэсгийг дэлбэрэх аюултай бүсэд тооцно. Тусгаарласан бүсээс гадна орчинд гал гарах, дэлбэрэх аюултай эсэхийг агаар мандал дахь аюултай бодисын агууламжийн түвшнээр тодорхойлно.

7 Хэрэглэх материалд тавих шаардлага

- 7.1** Будгийн ажилд ашиглах материалыг хэрэглэж байхдаа тухайн материалын хэмжээг зөв тооцоолохоос гадна шатах, улайсах, дэлбэрэх шинж чанар, температурын хязгаар, өөрөө шатаж дэлбэрэх чадвар, аюултай орчин үүсгэж болзошгүй нөхцөл зэрэг хортой болон аюултай үйлчлэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг, дагаж мөрддөг байх ёстой.
- 7.2** Эд анги угсрах нэгжийг угааж, тосыг нь арилгахад ашиглах материал нь шатамтгай чанартай байж болохгүй бөгөөд шатамтгай материалыг зөвхөн технологийн шаардлагын дагуу ашиглана.

8 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг байрлуулахад тавих шаардлага, ажлын байрын зохион байгуулалт

- 8.1** Тоног төхөөрөмжийг байрлуулахдаа үйлчилгээ үзүүлэх нөхцөл болон аваарын үед ажилтныг аюулгүй нүүлгэн шилжүүлэх, тусгаарлах боломжийг бүрэн хангасан байх ёстой
- 8.2** Үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлс ажилтанд нөлөөлөхөөс сэргийлэн тоног төхөөрөмжийг зохистой зайд байрлуулах шаардлагатай.
- 8.3** Тоног төхөөрөмжийн хоорондох зай нь тээврийн хэрэгсэл, тээвэрлэх эд зүйлийн овор хэмжээтэй уялдсан байх ба төхөөрөмж хоёрыг холбосон захуудаас 0.7 метрээс багагүй өргөнтэй байхаар тооцсон байвал зохино.
- 8.4** Тоног төхөөрөмжийн засвар, үзлэг, үйлчилгээ хийх зориулалтын зай нь хамгийн багадаа 0.8 метр байна
- 8.5** Будгийн ажлын цахилгаан тоноглол нь гал түймэр гарах, дэлбэрэх эрсдэлийн эсрэг аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байна.

9 Үйлдвэрлэлийн үндсэн материал, хаягдлын хадгалалт, тээвэрлэлтэд тавих шаардлага

- 9.1** Лак, будгийн материал, шингэлэгч, найруулагч, бэхжүүлэгч болон угаагч, тос арилгагч, өнгөлөгчийг бэлтгэхэд ашиглах хагас боловсруулсан материалыг галын аюулгүй байдлын шаардлага хангасан, агааржуулалтын системтэй тусгай агуулахад хадгална.
- 9.2** Будгийн материалын хоногийн нөөцийг агааржуулалтын систем болон галын хамгаалалтын хэрэгслээр тоноглогдсон агуулахад хадгална.
- 9.3** Будгийн материалын хоногийн нөөцийг агааржуулалтын систем болон галын хамгаалалтын хэрэгслээр тоноглогдсон агуулахад хадгална.

- 9.4** Хэрэглэхэд бэлэн болсон лак, будгийн материалыг ажлын байранд тусгайлан зориулсан хоолой, дамжуулах шугамаар дамжуулан хүргэнэ.
- 9.5** Ажил дууссаны дараа хэрэглэгдээгүй үлдсэн будаг, шингэлэгч, найруулагчийг будаг бэлтгэх хэсэг эсвэл агуулахад зориулалтын саванд юүлж буцаана. Дахин ашиглах боломжгүй материалыг зохих журмын дагуу хаягдалд шилжүүлнэ.
- 9.6** Лак, будаг, шингэлэгч, найруулагч болон бусад шатамхай материалын хаягдалтай савыг үндсэн үйлдвэрийн байруудаас тусгаарласан, агааржуулалтын системтэй агуулахад хадгална. Эсвэл үйлдвэрээс аюулгүй зайд байрлуулсан талбайд хадгалж болно.
- 10 Ажилтны хувийн хамгаалах хэрэгсэл тавих шаардлага**
- 10.1** Будгийн ажил гүйцэтгэж буй ажилтнууд нь холбогдох технологийн баримт бичигт заасан хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн ашиглах ёстой.
- 11 Аюулгүй ажиллагааны шаардлагын биелэлтэд тавих хяналт**
- 11.1** Үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн агууламжид тавих хяналтын давтамж, хэмжээг хийгдэж буй ажлын төрөл, ашиглагдаж байгаа материалын онцлогоос хамааран тогтооно.
- 11.2** Будах ажлын технологийн горим, хэрэглэж буй материалын нэр төрөл өөрчлөгдөх, эсвэл агааржуулалтын системийг шинэчлэх үед үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн түвшнийг дахин шалгаж үзвэл зохино.
- 11.3** Агаар мандалд дэлбэрэлт үүсгэх нөхцөл бүрдүүлж болзошгүй, шатамхай болон амархан авалцах бодис хуримтлагдах боломжтой хэсгүүдэд зохих хэмжилт, хяналтыг тогтмол хийж байх ёстой.

ТӨГСӨВ.

А хавсралт
(мэдээллийн)

Үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлүүд

Хүснэгт А.1

Будгийн ажлын үед гарч болох үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлүүд

Д/д	Аюултай, хортой хүчин зүйлүүд	Тайлбар
1	Хөдөлгөөнт машин, механизм	Машин тоног төхөөрөмжтэй ойр ажиллах, мөргөлдөх, шүргэх, хавчуулах эрсдэл
2	Будах төхөөрөмжийн хамгаалалтгүй хөдөлгөөнт эд анги	Хуруу, гар хавчуулах, тасруулах эрсдэл
3	Буцалж буй бүтээгдэхүүн	Түлэгдэх аюул
4	Агаарын хэт их тоосжилт, ууршилт	Амьсгалын замын цочрол, архаг өвчлөл
5	Шингэн бодис, уур, халуун гадаргуу	Түлэгдэлт, хэт халалтаас үүдэлтэй эрүүл мэндийн хохирол
6	Хэт өндөр/бага температуртай ажлын орчин	Гипотерми, гипертерми, дулааны цочрол
7	Хэт их дуу чимээ, шуугиан, чичиргээ	Сонсгол муудах, мэдрэлийн ядаргаа, дотор муухайрах
8	Хэт ягаан, улаан туяа	Арьс, нүдний гэмтэл, дулааны цацрагын нөлөөлөл
9	Цахилгаан хамгаалалтгүй гүйдэл дамжуулах хэсэг	Цахилгаанд цохиулах, галын аюул
10	Агаарт хэт их статик цэнэг хуримтлагдах	Оч үүсэж дэлбэрэх, шаталт өдөөх аюул
11	Нунтаг ба шингэн материалыг дамжуулах үед үүсэх цахилгаанжилт, хүчдэл	Цахилгаан шок, дэлбэрэлтийн эрсдэл
12	Даралтат будаг шүршигчийн хэвийн горим алдагдах	Хүчтэй шүршилтээс үүдэх гэмтэл
13	Хорт бодисуудын арьс, салст, амьсгалын замаар дамжих нөлөөлөл	Химийн хордлого, мэдрэл, амьсгалын замын өвчлөл